



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 23 өдөр

Дугаар А/325

Арвайхээр сум

Тусгай зориулалтын агнуурын амьтныг агнах
гэрээ байгуулах, эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Зөвшөөрлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2.1.1, Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.1, 29¹ дүгээр зүйлийн 29¹.7, “Тусгай зориулалтаар 2024 онд агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээг тогтоох тухай” Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 89 дүгээр тогтоол, “Амьтны экологи эдийн засгийн үнэлгээг шинэчлэн батлах тухай” 2023 оны 260 дугаар тогтоол, “Босго үнийн хэмжээ тогтоох тухай” 2023 оны 261 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өвөрхангай аймгийн хэмжээнд тусгай зориулалтаар агнуурын амьтныг агнах, зөвшөөрөл олгох дуудлага худалдаанд хамгийн өндөр үнийн санал ирүүлсэн аж ахуйн нэгжүүдийн нэрсийн жагсаалтыг 1 дүгээр, дахин дуудлага худалдаанд тусгай зориулалтаар агнуулах агнуурын амьтны зүйлийн нэр, тоо толгойг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Тусгай зориулалтын агнуурын амьтныг агнах зөвшөөрөл олгох дуудлага худалдаанд оролцож, зөвшөөрлийн үнэ төлсөн хамгийн өндөр үнийн санал ирүүлсэн аж ахуйн нэгжүүдтэй “Агнуурын амьтныг агнах, барих” гэрээ байгуулж, төлбөр хураамжийг хуульд заасан хугацаанд, холбогдох дансанд төвлөрүүлж, дуудлага худалдааны ялагч нарт тусгай зөвшөөрөл олгох ажлыг зохион байгуулж ажиллахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Г.Баясгаланд)-т үүрэг болгосугай.

3.Дуудлага худалдаанд оролцоод ялагч болсон ч зөвшөөрлийн үнийг төлөөгүй иргэн, аж ахуйн нэгжүүдийн дуудлага худалдааг хүчингүй болгож, хуулийн хугацаанд дахин зохион байгуулж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайханд)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



И.ДОРЖСҮРЭН

6224 11 679

Аймгийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 115/25 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт



ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН АГНУУРЫН ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ ХАМГИЙН ӨНДӨР
ҮНИЙН САНАЛ ИРҮҮЛСЭН АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН НЭРС

Амьтны зүйлийн нэр	Экологи эдийн засгийн үнэлгээ	Дэнчин үнэ	Босго үнэ	Өсгөх доод үнэ	Өсгөх дээд үнэ	Ялагчийн нэр	Төлвөл зохих мөнгөн дүн
Янгир, Тэх 01	5,300,000	106,000	1,060,000	150,000	500,000	Говь жи ти эс ХХК	25,754,000
Янгир, Тэх 04	5,300,000	106,000	1,060,000	150,000	500,000	Аттон аммон ХХК	26,694,000
Янгир, Тэх 05	5,300,000	106,000	1,060,000	150,000	500,000	Говь жи ти эс ХХК	25,894,000
Халиун буга 01	12,700,000	254,000	2,540,000	300,000	1,200,000	Аттон аммон ХХК	2,886,000
Халиун буга 02	12,700,000	254,000	2,540,000	300,000	1,200,000	Аттон аммон ХХК	2,886,000
Халиун буга 03	12,700,000	254,000	2,540,000	300,000	1,200,000	Аттон аммон ХХК	2,886,000
Бор гөрөөс 01	645,000	64,500	129,000	70,000	300,000	Говь жи ти эс ХХК	269,000
Бор гөрөөс 02	645,000	64,500	129,000	70,000	300,000	Говь жи ти эс ХХК	269,000
Сараал чоно 01	1,113,000	113,000	226,000	150,000	500,000	Алтай зэв экспидейшн ХХК	413,000
Сараал чоно 02	1,113,000	113,000	226,000	150,000	500,000	Аттон аммон ХХК	413,000
Дүн							88,364,000

Аймгийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр
сарын 25 -ний өдрийн 1325 дугаар
захирамжийн 2 дугаар хавсралт



ДАХИН ДУУДЛАГА ХУДАЛДААНД ТУСГАЙ ЗОРИУЛАЛТААР
АГНУУЛАХ АГНУУРЫН АМЬТНЫ ЗҮЙЛИЙН НЭР, ТОО ТОЛГОЙ

№	Сумын нэр	Агнуурын бүс нутгийн нэр	Угалз	Тэх
1	Богд	Арц богд	1	2
2	Баруунбаян-Улаан	Бага богд		2
		Өшгөгийн нуруу	2	
3	Нарийнтээл	Тахилгат мандаа	1	
4	Хайрхандулаан	Залаа	1	
6	Уянга	Жаргалант		1
Нийт			5	5

-оОо-